

## ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2024 онд хэрэгжүүлсэн 97 арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, дүгнэлт

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 97 арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт- шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа:

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100 хувийн гүйцэтгэлтэй 96 арга хэмжээ;
2. Гол үр дүн гарч эхэлж байгаа, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувийн гүйцэтгэлтэй 1 арга хэмжээ;

Дээр дурдсан арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг арифметик дунджаар тооцон үзэхэд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 99.89 хувьтай үнэлэгдсэн болно.

Дээрх 97 арга хэмжээнээс амжилттай хэрэгжсэн буюу үр дүнтэй хэд хэдэн арга хэмжээ байгаагаас 100 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээг онцлон дурдвал;

Гүйцэтгэлийн тайлангийн 62 дугаар дахь “Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах” арга хэмжээг “Тус газрын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/323-01/343 дугаартай албан бичгээр 21 аймгийн засаг дарга нартай хамтран ажиллах саналыг хүргүүлж, Төрөөс үзүүлж байгаа цахим

үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах хоёрдугаар шатны сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл 21 аймагт үе шаттайгаар зохион байгуулж 589 байгууллагын 21,805 төрийн албан хаагчийг хамруулсан.

- Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар, Газрын алба, Биеийн тамир спортын хороо, Статистикийн хороо, Худалдан авах ажиллагааны алба, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн нийт төрийн албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 10,11-ний өдөр “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж 235 албан хаагчийг хамруулсан.
- Ражив Гандийн нэрэмжит үйлдвэрлэл, урлалын политехник коллежийн багш нарт 2024 оны 01 дүгээр сарын 10,11-ны өдрүүдэд “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж 200 оюутан суралцагчдыг хамруулсан.
- Батлан хамгаалах яамны харьяа Аж үйлдвэрийн нэгдлийн 20 албан хаагчид 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хорооны 580 иргэнд 2024 оны 01 дүгээр сарын 24,25,26-ны өдрүүдэд “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Зэвсэгт хүчний 334 дүгээр ангийн 80 албан хаагчид 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Өмнөговь аймгийн 14 сумын нийт 58 байгууллагын 973 иргэн, төрийн албан хаагчийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтад хамруулсан.
- Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн 150 албан хаагч, цэргийн албан хаагчийг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтад харуулсан.
- Онцгой байдлын Ерөнхий газрын 119 дүгээр ангийн Шуурхай удирдлагын газрын 30 албан хаагчид 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 30 албан хаагчид 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдөр “Цахим хөгжлийг дэмжих” багц хуулийн танилцуулга сургалт зохион байгуулсан.
- Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 1, 31, 45, 6, 11, 2, 4, 3, 16, 159, 35, Эрдмийн хөтөч цогцолбор сургууль, 71-р сургуулиудад 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд сургалт зохион байгуулж 3,249 багш, ажилтан, ахлах ангийн сурагчдыг хамруулсан.
- Сүхбаатар дүүргийн Ражив Гандийн үйлдвэрлэл, урлалын политехник коллежийн 250 оюутан, ахлах ангийн сурагчдад 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр “Орчин үеийн дэвшилтэт технологи”, “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 23, 24, 112, 5, 50, 17, 49, 39, 57, 61, Насан туршийн боловсролын төв, 72, 37, 117, 149, Бадмаараг сургуулийн нийт 1,615 багш, ажилтан, ахлах ангийн сурагчдад 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрүүдэд “Орчин үеийн дэвшилтэт технологи”, “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- Хэнтий аймаг, Чингис хот, Жаргалт хаан, Цэнхэрмандал, Мөрөн сумын 947 иргэн, төрийн албан хаагч, ахлах ангийн сурагчдад 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд “Орчин үеийн дэвшилтэт технологи”, “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.

- Чингэлтэй дүүргийн 22-р хорооны 50 иргэнд 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалт буюу Тоон гарын үсэг ба түүний хэрэглээ ач холбогдол, Иргэд төрийн албан хаагчдад хэрэгцээт цахим хуудаснууд, Мэдээллийн аюулгүй байдал гэсэн сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.
- Хан-уул дүүргийн Засаг даргын тамгын газар, 25 хорооны нийт 120 төрийн албан хаагчид 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.
- “Цахимд хэвшье” digital first-D1 арга хэмжээний хүрээнд 04 дүгээр сарын 29-ний адар Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 230 сурагч, төрийн албан хаагчдад “Тасралтгүй суралцах” сэдвээр өдөр сургалт зохион байгуулсан.
- Сүхбаатар дүүргийн Шинэ үе сургуулийн 3 дугаар ангийн 170 сурагчдад “Ухаалаг утасны зохистой хэрэглээ” сэдвийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр сургалт зохион байгуулсан.
- Багш хөгжлийн ордонд Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын 100 нийгмийн ажилтан, сэтгэл судлаач нарт “Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэл” сэдвийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр сургалтыг зохион байгуулсан.
- “Дулааны 3 дугаар цахилгаан станц”-ын 110 ажилтан, албан хаагчдад “Цахим ур чадвар” дээшлүүлэх сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан.
- Кибер аюулгүй байдлын “Цахимд зөв байя” гуравдугаар шатны сургалтын хүрээнд тус газрын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/356 дугаартай албан бичгээр 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Засаг дарга нартай хамтран ажиллах саналыг хүргүүлж, сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулан ажилласан. “Бүх нийтийн цахим ур чадвар”-ыг дээшлүүлэх гуравдугаар шатны сургалтын хүрээнд нийт 928 байгууллагын төрийн албан хаагч, ажилт, төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн ажилтан, ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их, дээд сургуульд суралцагч, багш, ажилтан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг 24,276 иргэнийг хамруулсан.
- Нийслэлийн хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрүүдийн хооронд Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс, Засаг даргын Тамгын газар, Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монгол Улсын боловсролын их сургуулийн харьяа Дүрслэх урлаг, технологийн сургууль, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар зэрэг нийт 13 байгууллагын 397 албан хаагчийг хамруулсан.

Орон нутагт зохион байгуулсан сургалтын хүрээнд:

- Архангай аймгийн 28 байгууллагын 1000;
- Баян-өлгий аймгийн 26 байгууллагын 945;
- Баянхонгор аймгийн 20 сумын 48 байгууллагын 985;
- Булган аймгийн 40 байгууллагын 1017;
- Говь-алтай аймгийн 27 байгууллагын 650;
- Говьсүмбэр аймгийн 24 байгууллагын 1064;

- Дархан-уул аймгийн 7 байгууллагын 1191;
- Дорноговь аймгийн 14 сумын 81 байгууллагын 1015;
- Дорнод аймгийн 7 сумын 31 байгууллагын 1124;
- Дундговь аймгийн 57 байгууллагын 2005;
- Завхан аймгийн 40 байгууллагын 729;
- Орхон аймгийн 2 сумын 45 байгууллагын 1243;
- Өвөрхангай аймгийн 19 сумын 22 байгууллагын 545;
- Өмнөговь аймгийн 5 сумын 71 байгууллагын 1984;
- Сүхбаатар аймгийн 110 байгууллагын 1142;
- Сэлэнгэ аймгийн 17 сумын 36 байгууллагын 2010;
- Төв аймгийн 27 сумын 195 байгууллагын 1382;
- Увс аймгийн 27 байгууллагын 783;
- Ховд аймгийн 365;
- Хөвсгөл аймгийн 1252;
- Хэнтий аймгийн 40 байгууллагын 1451 иргэнийг тус тус хамруулсан байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан “Гига” санаачилга, Боловсрол шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран ерөнхий боловсролын сургуульд түшиглэсэн “Олон нийтийн мэдээллийн ажилтан” (ОНЦМА) бэлтгэх төслийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрүүдэд Дархан-Уул, Орхон, Хэнтий, Дорнод, Дорноговь аймгийн ерөнхий боловсролын мэдээлэл зүйн 56 багшид цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан.

Нийт: 55,726 албан хаагч, иргэдэд сургалт зохион байгуулсан” гэж;

Гүйцэтгэлийн тайлангийн 95 дахь “Төрийн үйлчилгээний процессыг оновчлох, дахин загварчлах, цахимжуулах ажлын хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах” арга хэмжээг “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүнд суртлыг бууруулах зорилтын хүрээнд тус газар нь Жижиг, дунд үйлдвэрийн газар, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв улсын төсөвт үйлдвэрийн газар, “Сис арт” ХХК-тай хамтран Жижиг, дунд үйлдвэрийн газрын хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин загварчлал хийж үйл ажиллагааг нь оновчлох, лавлагаа, тодорхойлолт, олон шатлалт үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2024 оны А/34 дүгээр тушаалаар байгуулсан. Жижиг, дунд үйлдвэрийн газрын төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, үйл ажиллагаанд дагаж мөрддөг дүрэм, журам, стратеги төлөвлөгөөний процессын зураглалыг хийж, бизнес процессын өнөөгийн нөхцөл байдлын тайлан, цаашдын үйл ажиллагаанд баримтлах загварыг шинэчлэн боловсруулсан.

- “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран орон нутгийн төрийн байгууллагын төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн үйлчилгээнд процессын шинжилгээ хийх, дахин загварчлах, шинээр цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний судалгааг гаргах ажлын хэсэг нь дараах арга хэмжээг авч ажилласан.

- Орон нутаг дахь төрийн захиргааны 25 агентлагийн цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний нөхцөл байдлын шинжилгээ;
- Ашиглаж буй системүүдийн судалгаа;
- Цахим үйлчилгээ, сэтгэл ханамжийн судалгаа;
- Ахмадуудад зориулсан сургалт;
- Байгууллагуудын олон шатлалт үйлчилгээний сайжруулалт хийх арга хэмжээ;

- Хуучин үйлчилгээний системд өөрчлөлт хийх;
- Шинээр нэвтрэх үйлчилгээний бодлогын даалгавар боловсруулах;
- Сумдын үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулах;
- ERP/DOCX сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан.
- Стандарт, хэмжил зүйн газраас хүн, хуулийн этгээдэд үзүүлдэг 6600 орчим И стандартыг төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангаж ажилласан.
- Стандарт, хэмжил зүйн газрын үзүүлж байгаа үйлчилгээнд процессын дахин загварчлал хийж үйл ажиллагааг нь оновчлох, лавлагаа, тодорхойлолт, олон шатлалт үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн” гэж тус тус тайлагнажээ.

Түүнчлэн тус газрын 97 арга хэмжээнээс гол үр дүн гарч ирж байгаа, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90 хувийн гүйцэтгэлтэй гэж үзсэн 1 арга хэмжээг дурдвал;

Гүйцэтгэлийн тайлангийн 92 дахь “Олон улсын стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах” арга хэмжээг “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001, Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус газрын 9 албан хаагч дотоод аудитор бэлтгэх сургалтад хамруулж 4 журмын төслийг боловсруулсан” гэж тайлагнасан бөгөөд тухайн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй буюу Олон улсын стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулж батлаагүй байна. Иймд тус арга хэмжээг дараа жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

#### **Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /зөвлөмж/**

Цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Арга хэмжээний нэршил болон агуулгын давхцалгүй төлөвлөгөө боловсруулах;
2. Нэг арга хэмжээг хэд хэд болгон хувааж төлөвлөхгүй байхад анхаарах.

---oOo---